

Байгууллагын нэр: Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар

Тайлан болосвуулсан албан хаагч: Х.Билигсайхан

Холбоо барих мэдээлэл

Утас: 70140423

имэйл хаяг: biligsaikhan.hhaag@gmail.com

Тайлан өгсөн огноо: 2018.06.25

2017 ОНЫ ГАДААД АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН

I. Гадаад томилолт

Д/д	Улс, хот	Албан тушаал	Хүний тоо	Хугацаа	Зорилго	Төсөв	Үр дүн
1	БНСУ, Кимхэ хот	Газар тариалангийн хэлтсийн мэргэжилтэн Ч.Авирмэд, Хүнсний үйлдвэрлэлийн хэлтсийн мэргэжилтэн Ч.Батхүү	2	2017.12.08–2018.03.06	"Хүлэмжийн аж ахуй" сэдэвт туршлага судлах 90 хоногийн сургалтанд хамрагдсан.	"Грийн агро технологийн төв"	Бүгд Найрамдах Солонгос Улсын хөрөнгө оруулалттай "Грийн сити агро технологийн төв"-тэй НХХААГ 2017 оны 11 дүгээр сарын 11 –ний өдөр хамтран ажиллах санамж бичиг байгуулсан бөгөөд тус санамж бичгийн хүрээнд хүнсний үйлдвэрлэлийн хэлтсийн мэргэжилтэн Ч.Батхүү, Газар тариалангийн хэлтсийн мэргэжилтэн Ч.Авирмэд нар БНСУ-ын Кимхэ хотод "Хүлэмжийн аж ахуй"-н чиглэлээр туршлага судлах сургалтад 2017 оны 12 дугаар сарын 08-ны өдрөөс 2018 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн хооронд хамрагдсан. Тус туршлага судлах сургалтын хүрээнд мэргэжилтэн Ч.Авирмэд "Үрсэлгээний хүлэмжийн аж ахуй"-д туршлага судалсан бөгөөд хүлэмжинд Өргөст хэмх, тарвас, амтат болон гашуун чинжүү, тэжээлийн таримал, эрдэнэ шиш зэрэг тухайн бүс нутгийн онцлогт тохирсон тарималуудыг 21-35 хоногийн дотор мэргэжлийн өндөр түвшинд агротехнологийн стандартын дагуу бүтэн автоматжуулсан хүлэмжинд бойжуулах туршлага судалсан. Мэргэжилтэн Ч. Батхүү "Улаан лоолийн хүлэмжийн аж ахуй"-д туршлага судалсан бөгөөд Цэцгийн тоос хүртээх зорилгоор зөгий ашиглах мөн тусгай бодис, найрлагаар найруулсан уусмалыг усалгаанд ашиглах талаар судалсан. Ажиллаж байсан хүлэмж нь бүрэн автомат бөгөөд усалтын систем, дуслын усалгаа, агааржуулалт, халаалтыг цогцоор нь шийдсэн орчин үеийн шийдэлтэй байсан.
2	БНСУ, Кимхэ хот	Мэргэжилтэн А.Баянжаргал	1	2017.12.08–2018.03.06	"Хүнсний боловсруулах салбар" тай танилцах туршлага судлах	"МОСАН ЭФ ЭС" ХХК	БНСУ-ын "МОСАН ЭФ ЭС" ХХК-тай 2018 оны 02 дугаар сарын 20-ны өдөр хамтран ажиллах санамж бичиг байгуулж, санамж бичгийн хүрээнд мэргэжилтэн А.Баянжаргал 2017 оны 12 дугаар сарын 08-аас 2018 оны 03 дугаар сарын 06-ны өдрийг хүртэл тус компаний "Кимчи боловсруулах үйлдвэр"-т туршлага судалсан. Туршлага судлах сургалтаар БНСУ-ын хүнсний үйлдвэрлэлийн салбарын стандарт, хүнсний аюулгүй байдал, хангамж, БНСУ-д хэрэгжүүлж буй Олон улсын стандартуудыг судласан.
3	БНХАУ, Хөх хот	Газар тариалангийн хэлтсийн мэргэжилтэн Д.Зандармаа	1	2018.04.17-2018.05.07	"Хүлэмжинд хүнсний ногоо тарьж ургуулах технологи"	ХХААХҮЯ	БНХАУ-ын Худалдааны яам, Монгол Улсын ХХААХҮЯ-ны найрамдалт хамтын ажиллагааны хүрээнд Хөх хотын Тариалангийн их сургуультай хамтран "Монголын хүлэмжинд хүнсний ногоо тарьж ургуулах технологи" сэдэвт сургалтад 21 аймгийн Хөдөө аж ахуй хариуцсан мэргэжилтэн, аж ахуйн нэгжийн төлөөлөл болон агрономич нийт 24 хүн хамрагдсан. Энэхүү сургалт нь БНХАУ-ын Хөх хотын хүлэмжийн хүнсний ногооны салбарын арга, туршлага, тус улсын сүүлийн үеийн техник, технологийн дэвшилтэт аргыг газар дээр нь үзэж, хүлэмжинд навчит ногоо, буурцагт ургамал, лооль, хэмх гэх мэт голлон тариалах хүнсний ногооны тариалах технологи, өвчин хортонтой тэмцэх талаар танхимын болон дадлагын арга хэлбэр хосолсон сургалт болсон.
4	БНЭУ, Хайдрабад хот	Эрчимжсэн мал аж ахуйн хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Мөнхтуяа	1	2018.05.01-2018.05.15	"Орчин үеийн тахианы аж ахуйн менежмент"	ХХААХҮЯ	Монгол улсаас УМЭАЦТЛ-ын шинжээч эмч Ц.Оюундэлгэр, Н.Сэрчмаа, НМХГ-ын байцаагч Э.Оюунсоёмбо, Мал хамгаалах сангийн мэргэжилтэн н.Мөнх-Эрдэнэ, Халх гол төслийн нэгжийн мэргэжилтэн Х.Ханддорж нарын бүрэлдэхүүнтэй хамрагдсан бөгөөд нийт 110 цагийн танхимын болон дадлагын хэлбэр хосолсон сургалт болсон. Сургалтын хүрээнд тус улсын тахианы аж ахуйн хөгжлийн талаар цогц мэдээллийг авч мэргэжлийн байгууллагууд болон үндэсний судалгааны хүрээлэн, тахианы аж ахуй, тэжээлийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай танилцсан. Сургалтаар шувууны аж ахуйн стандарт, бүртгэлжүүлэлт, шинжилгээний түргэвчилсэн аргууд, тэжээлийн менежмент, үржлийн менежмент, хүнсний бүтээгдэхүүний боловсруулалт, шувууны сангасыг боловсруулан биогаз үйлдвэрлэх зэрэг манай улсад хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай асуудлуудыг хөндсөн үр өгөөжтэй сургалт болсон.

5	БНСУ, Кимхэ хот	Эрчимжсэн мал аж ахуйн хэлтсийн мэргэжилтэн Т.Нарантуяа	1	2018.03.16-2018.06.13	"Хүнсний боловсруулах салбар"-тай танилцах туршлага судлах	"МОСАН ЭФ ЭС" ХХК	БНСУ-ын "МОСАН ЭФ ЭС" ХХК-тай 2018 оны 02 дугаар сарын 20-ны өдөр хамтран ажиллах санамж бичиг байгуулж санамж бичгийн хүрээнд мэргэжилтэн Т.Нарантуяа 2018 оны 03 дугаар сарын 16-аас 2018 оны 06 дугаар сарын 13-ны өдрийг хүртэл тус компаний "Кимчи боловсруулах үйлдвэр"-т туршлага судалсан. Туршлага судлах сургалтаар БНСУ-ын хүнсний үйлдвэрлэлийн салбарын стандарт, хүнсний аюулгүй байдал, хангамж, БНСУ-д хэрэгжүүлж буй Олон улсын стандартуудыг судласан.
II. Зочид төлөөлөгчид							
1	БНСУ, Инcheon хот	БНСУ-ын Инcheon хотын хөдөө аж ахуйн технологийн төв	3	2017.11.28	Хотуудын хөдөө аж ахуйн салбарын хамтын ажиллагаа	Байхгүй	Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Д.Баянбат, БНСУ-ын Инcheon хотын хөдөө аж ахуйн технологийн төвтэй хамтран ажиллах санамж бичиг байгуулах, Хан-Уул дүүргийн 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт орших 8 га газарт "Агропарк" сургалтын төв байгуулах чиглэлээр санал солилцсон. НХХААГ-аас төсөл хэрэгжүүлэх боломжтой газруудын байршлыг БНСУ-ын төлөөлөгчдөд үзүүлсэн бөгөөд БНСУ-ын талаас байршлыг Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороонд болгон өөрчлөх саналын дагуу судлаж "Бэлчээрийн менежмент төслийн нэгж"-ийн газар дээр байгуулах боломжтой гэсэн саналыг БНСУ-ын талд өгсөн байгаа. Одоогийн байдлаар хариу ирээгүй байна.
III. Гадаад арга хэмжээ							
1							
IV. Гэрээ, Санамж бичиг							
Д/д	Улс, хот	Гадны байгууллагын нэр, албан тушаал	Төрөл	Огноо	Тэргүү	Гарын үсэг зурсан байгууллагын нэр, албан тушаал	Зорилго/Үр дүн
1	БНСУ	"МОСАН ЭФ ЭС" ХХК	СБ	2018.02.20	Хамтран ажиллах тухай	НХХААГ-ын дарга Д.Баянбат	Зорилго: Хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн салбарт хоёр байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх, салбарын хөгжилд хувь нэмэр оруулах салбарын хүний нөөцийг чадавхжуулах
2	БНСУ	БНСУ-ын Кимхэ хотын хөдөө аж ахуйн технологийн төв	СБ	2018.03.28	Хамтран ажиллах тухай	НХХААГ-ын дарга Д.Баянбат	Зорилго: Хоёр хотын хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх, техник, технологийн дадлага, сургалтыг хамтран зохион байгуулж салбарын хүний нөөцийг чадавхжуулах

ХЯНАСАН:
ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА

Р.УНДАРМАА

БОЛОВСРУУЛСАН:
ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Х.БИЛИГСАЙХАН